



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/156

Ховд

Комисс томилох тухай

Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 9/05 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг 2020 оны 03 дугаар сарын 19-нд зохион байгуулж явуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга: Ц.Ганданповрон – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлт хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Л.Батгэрэл – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлт хэлтсийн эдийн засаг, стратеги, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн

Ц.Сувдаа -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлт хэлтсийн Зам тээвэр, уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн

Б.Наранбаатар - Жаргалант сумын Газрын даамал

Нарийн бичгийн дарга:

Э.Дөлбадрал - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

2. Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг хууль тогтоомжид нийцүүлэн явуулж хяналт тавин ажиллахыг комиссын дарга /Ц.Ганданповрон/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

